Амьдралын чанарын үзүүлэлтийг хамрын таславчийн засах хагалгааны дараа үнэлсэн байдал

А.Чанцалдулам[1], А.Аюурзана[2], Р.Бямбасүрэн[3], С.Энэбиш[4]

[1]АШУҮИС
[2]АШУҮИС-ийн өрхийн анагаах ухааны тэнхим
[3]ШУГТЭ-ийн чих хамар хоолойн тасаг
[4]АШУҮИС-ийн Анатомийн тэнхим

Түлхүүр үг:
Амьдралын чанар
Хамрын таславчийг засах хагалгаа
Хамрын таславчийн муруйлт
NAIF асуумж

Товч утга: Үндэслэл: Хамрын таславчийн муруйлттай явах тусам хамрын амьсгал саадтай болж буюу хамар битүүрч улмаар энэ нь амьсгаадуулах, ядраах, унтахдаа хурхирах, оюуны ачаалал авах чадваргүй болох зэрэг олон тооны өөрчлөлтөнд хүргэж байгаа буюу хүний амьдралын чанарын эрс бууруулж байна. **Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй:** Судалгаанд 42 үйлчлүүлэгч оролцсон, үүнээс 23 эр (57,2%, n=38), дундаж нас 37+-19 нас, 19 эмэгтэй (42.8%, n=38), дундаж нас 35+-15 нас. ШУГТЭ-ийн чих хамар хоолойн тасагт ХТМЗ хагалгаа хийлгэсэн үйлчлүүлэгчдийг сонгож судалгаандаа хамруулаа. NAIF асуумжийг ашиглан хагалгааны дараа тухайн хүнд илэрч байгаа шинж тэмдэг, зовиурыг үнэлж амьдралын чанарт хэрхэн нөлөөлж байгааг илрүүллээ. **Үр дүн:** Биеийн ба сэтгэл санааны байдал хамрын таславчийн муруйлтийг засах хагалгаанаас 1 сарын дараа сайжирсан байна. Хамрын таславчийн муруйлтийг засах хагалгаанаас хойш 12 сарын дараа нийгмийн ба оюун ухааны чадвар сайжирсан байлаа.

ӨГҮҮЛЭЛ

Үндэслэл: Хамрын таславчийн муруйлт нь зонхилон тохиолдож байгаа эмгэгийн нэг юм. Нүүрний гэмтэл, нүүрний яс болон мөгөөрсний харилцан холбоогүй ургалт нь нүүрний ясны деформацийг үүсгэн хамрын таславчийн муруйлт үүсгэх үндсэн шалтгаан болж байна. Хамрын таславчийн муруйлттай явах тусам хамрын амьсгал саадтай болж буюу хамар битүүрч улмаар энэ нь амьсгаадуулах, ядраах, унтахдаа хурхирах, оюуны ачаалал авах чадваргүй болох зэрэг олон тооны өөрчлөлтөнд хүргэж байгаа буюу хүний амьдралын чанарын эрс бууруулж байна. Хамрын таславчийн муруйлтийг засах “септопластик” / цаашид хамрын таславчийн муруйлтийг засах хагалгаа -ХТМЗХ/ хагалгааг хийлгэж байна. Уг хагалгаа нь хамрын амьсгалыг сайжруулж амьдралын чанарыг дээшлүүлдэг боловч хагалгаанаас хойш хожуу хугацаанд хүндрэл илрэх тохиолдол гарч болдог.

Хэвлэлийн тоймоос харахад ХТМЗХ хийлгэсний дараа амьдралын чанар эрс дээшилсэн байдаг. Амьдралын чанарын индекс нь өвчин эмгэг бие махбодь, сэтгэл санаа, нийгмийн хувьд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэх чухал үзүүлэлт юм. Амьдралын чанарын ерөнхий болон тусгайлсан байдлаар үнэлсэн олон тооны судалгааны ажил байдаг. Энэ судалгаанаас үзэхэд хамар болон хамрын дайврын харшил, халдвар, ургалт зэрэг олон шалтгаанаас хамрын таславчийн муруйлт үүсдэг. Бид судалгаандаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн асуумж буюу NAIF (New assessment and information form to measure quality of life. P.Y.Hugenholtzand R.A.M.Erdman, 1995) ашиглан ХТМЗМА хийлгэсний дараа хүний амьдралын чанар хэрхэн өөрчлөгдөж байгааг илрүүлж тогтоолоо.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй: Судалгаанд 42 үйлчлүүлэгч оролцсон, үүнээс 23 эр (57,2%, n=38), дундаж нас 37+-19 нас, 19 эмэгтэй (42.8%, n=38), дундаж нас 35+-15 нас. ШУГТЭ-ийн чих хамар хоолойн тасагт ХТМЗ хагалгаа хийлгэсэн үйлчлүүлэгчдийг сонгож судалгаандаа хамруулаа. NAIF асуумжийг ашиглан хагалгааны дараа тухайн хүнд илэрч байгаа шинж тэмдэг, зовиурыг үнэлж амьдралын чанарт хэрхэн нөлөөлж байгааг илрүүллээ. Үйлчлүүлэгчээс асуумжийг авахдаа хагалгаанаас 1 сарын өмнө, хагалгаанаас хойш 1 сарын дараа, хагалгаанаас хойш 12 сарын дараа асуумжийг тус тус авлаа. Хагалгааны дараа үйлчлүүлгчид эмнэлзүйд гарах шинж тэмдгээр нь үнэлж, гарах зовиур нь амьдралын чанарт хэрхэн нөлөөлж байгааг үнэллээ. Амьдралын чанарыг 6 бүлэг үзүүлэлтээр ангилж үнэлэв. Үүнд:

1. Биеийн үйл ажиллагаа
2. Сэтгэлийн үйл ажиллагаа
3. Бэлгийн үйл ажиллагаа

4. Нийгмийн харилцаанд оролцох байдал
5. Оюуны ухааны чадвар
6. Эдийн засгийн байдал зэрэг тус тус орно.

Үр дүн: Хагалгаанаас өмнө үйлчлүүлэгчид хамрын амьсгал саадтай 42 (100%, n=42), амьсгалын замын архаг үрэвсэлтэй 42 (100%, n=42), нойр муудах 42 (100%, n=42), 11 (26,1%, n=42) унтаж байхдаа хурхирах зэрэг шинж тус тус илэрч байв. Хагалгааны дараа үйлчлүүлэгчид эмнэл зүйн сайжрал 100% илэрч байлаа. 42 (100%, n=42) хүнд хамрын амьсгал саадгүй болж, 18 үйлчлүүлэгчид 42 (100%, n=42) амьсгалын замын үрэвсэлт өвчнөөр өвчлөх нь буурч, 21 (50%, n=42) нойр сайжран, 11 (26,1%, n=42) унтаж байхдаа хурхирахгүй болсон. Хагалгаа хийлгэсний дараа 19 (45,2%, n=42) хүн амьсгалын замын үрэвслээр өвчилж байсан ч эмгэг болж хүндрээгүй. 25 (59,5%, n=42) нойр муудсан хэвээр байсан хамрын таславч засагдсанаар сэтгэл зүй дээшилж, амьдралын чанар сайжирсан байлаа. Үр дүнгээс үзэхэд 23 (54,7%, n=42) хамрын амьсгал бүрэн сайжирч /хагалгаа хийлгэснээс 1 сарын дотор/, хагалгаанаас хойш 1 сарын дараа хамрын амьсгал бүх үйлчлүүлэгчдэд бүрэн сайжирсан байлаа. Хагалгаанаас хойш 1 сарын дараа хамар битүүрэх 7 (16,6%, n=42) байдал ажиглагдаж байв. Хагалгаа хийлгэснээс хойш нэг жил болоход 3 (7,1%, n=42) үйлчлүүлэгчид өвдөлтийн шинж илэрч байв. Амьсгал саадтай, хамраас цус гарах зэрэг хавсарн шинж нь нийт үйлчлүүлэгчийн 2-т буюу (4,7%, n=42), 1 үйлчлүүлэгчид (2,3%, n=42) хагалгаа хийлгэснээс хойш үнэрлэх мэдрэмж муудсан, гэхдээ уг өөрчлөлт 1 сарын дараа эргэн сэргэсэн байлаа.

Биеийн үйл ажиллагааны байдлыг үнэлхээд хагалгаанаас өмнө нийт үйлчлүүлэгчийн 48% дараах шинж тэмдэг илэрч байв. Үүнд: 1.амьсгаадах, ядрах, өдөрт тутамд хийдэг ажлын идэвх буурах зэрэг шинж тус тус багтана. Хагалгаанаас хойш 1 сарын дараа 57% дээрх шинж тэмдгүүд арилсан байлаа. Энэ нь амьдралын чанар сайжрах үндсэн үзүүлэлт болж байна. 12 сарын дараа дээрх шинж тэмдгүүд бүрэн арилж, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж байв. Энэ нь булчингийн хүч сайжирч, ачаалал даах чадвар ихэссэнтэй холбоотой байж болох юм. Сэтгэл зүйн хувьд хагалгаа хийлгээд нэг сар болоход 83% сайжрал гарч ирлээ. Үр дүнгээс үзэхэд невротик хэв шинжийн хүмүүст сэтгэлзүй илүү сайжирч байгаа дүр зураг гарлаа. Ялангуяа сэтгэл түгшил, санаа зовних байдал арилсан сайн тал илэрлээ. Хагалгаанаас хойш 12 сар болоход сэтгэл зүй 95% сайжрал ажиглагдлаа. Харин нийгмийн харилцаанд оролцох байдал /цаашид нийгмийн байдал буюу НБ/ болон оюун ухааны чадварын байдал /цаашид ОУБ/ зэрэг нь тухайн хувь хүний онцлогоос ихээхэн хамаарч байлаа. Нийгмийн харилцаанд илүүл идэвхтэй оролцох дүр зураг гараагүй боловч спортоор хичээллэх аливаа арга хэмжээнд оролцох сонирхол нэмэгдэж байв. Хагалгаанаас хойш нэг сарын дараа ОУБ-д тодорхой өөрчлөлт илэрсэнгүй.

Хагалгаа хийлгэснээс 12 сарын дараа оюун ухааны байдалд өөрчлөлт гарч, анхаарал төвлөрөлт нэмэгдэх, ой санамж сайжирсан байна. Мөн оюуны ачаалал авахад ядрах, толгой эргэх зэрэг шинж бүрэн арилжээ. Бэлгийн үйл ажиллагаанд хагалгааны өмнө болон дараа нь ямар нэгэн өөрчлөлт гарсангүй. Энэ нь асуумжийн зарим хэсгийг бөглөхгүй орхих, зарим зүйл дээр бусдад хэлэхдээ ичих, нуух, хувь хүний нууц учраас бичих ёсгүй гэж бодсонтой холбоотой байж болох юм. Эдийн засгийн хувьд бодитой өөрчлөлт илэрсэнгүй. Хагалгаанаас хойш нийгмийн ба оюун ухааны чадвар сайжирсан өөрчлөлт гарлаа.

Дүгнэлт:

1. Биеийн ба сэтгэл санааны байдал хамрын таславчийн муруйлтийг засах хагалгаанаас 1 сарын дараа сайжирсан байна.
2. Хамрын таславчийн муруйлтийг засах хагалгаанаас хойш 12 сарын дараа нийгмийн ба оюун ухааны чадвар сайжирсан байлаа.

Evaluation of the quality of life in a person after Septoplasty

A.Chantsaldulam[1], A.Ayurzana[2], R.Byambasuren[3], S.Enebish[4]

[1]MNUMS
[2]Department of Family Medicine of the MNUMS
[3]ENT department of Shastin Clinic Hospital,
[4]Department of Anatomy of the MNUMS

Introduction: The nasal septum deviation leads to difficulty breathing through the nose congestion, leading to a number of changes, such as dyspnea, tiredness, snoring at sleep, and inability to intellectual load, or dramatically reducing the quality of life of a person.
Materials and methods: Overall 42 clients were participated in the study, including 23 men (57.2%, n = 38), mean age 37 ±19 years, 19 women (42.8%, n = 38), mean age 35 ±15 years. The study was performed in the Shastin Clinic Hospital, the patients was selected who underwent LMP surgery in the ENT department. The study was used the NAIF questionnaire, we assessed the symptoms and pain of the person after surgery and found out how their quality of life was affected. Physical and mental well-being improved 1 month after surgery to correct nasal curvature.
Results: Twelve months after the surgery to correct the deviation of the nasal septum, social and mental abilities was improved.

Keywords: quality of life, septoplasty, nasal septum deviation, NAIF questionnaire